

ХЯТАДЫН ШИНЭ ДИПЛОМАТ БОДЛОГО БА МОНГОЛ-ХЯТАДЫН ХАРИЛЦАА

Д.Шүрхүү*

Сүүлийн жилүүдэд дэлхийн хамгийн их хүн амтай, хамгийн хурдтай хөгжиж буй эдийн засаг, коммунист засаглал бүхий Хятад оронд гарч буй эрс түргэн хувьсал өөрчлөлтийн талаар, түүний дотор тус орны гадаад бодлогын өөрчлөлтийн талаар ихээхэн шуугин бичих боллоо. Хятадын дипломат бодлогод гарч буй өөрчлөлтийг зарим хүмүүс алгуур удаан, дорвитой хувьсал өөрчлөлт гараагүй гэж үзэж болох боловч 10 жилийн өмнөх үетэй харьцуулан үзвэл чанарын өөрчлөлт гарсныг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй юм.

Энэ хувьсал өөрчлөлтийн шинэ үе шат 1990 оны эхэн үеэс эхэлсэн юм.

Хятадын эрх баригчид post-Tiananmen-ий ганцаардлаас гаргах, унасан нэр хүнд итгэлээ сэргээх, эдийн засгийн тогтвортой хөгжлөө хангахын тулд эдийн засгийн эрх ашгаа хамгаалах, дэмжин тэтгэх (promote), улс орны аюулгүй байдлаа бэхжүүлэх чиг шугамыг сонгож авсан билээ. Мөн түүнчлэн олон улсын харилцаа улам бүр нэг туйлт тогтолцоо руу шилжиж буй, өөрөөр хэлбэл АНУ-ын өргөжин тэлж буй нөлөөг бууруулах, хазаарлан барих үүднээс дэлхийн шинэ дэг журам тогтоохын төлөө байгаагаа илэрхийлэх болов. Хятад улс хоёр талын харилцааг ихээхэн чухалчлан, дэлхийн олон оронтой харилцаагаа өргөжүүлэн гүнзгийрүүлэх, сэргээн хөгжүүлэх, түншлэлийн янз бүрийн түвшинг бий болгож чадсан билээ. Олон улсын байгууллага, олон талт гэрээ хэлэлцээрт

хандах хандлага нь эрс өөрчлөгдөж, тэдгээрт нэгдэх, үйл ажиллагаанд нь оролцох оролцоо нь нэмэгдэж, аюулгүй байдал бүс нутгийн болон глобал асуудлуудад илүү уян хатан, илүү хариуцлагатай, бүтээлчээр хандах болжээ. Үүний тод жишээ нь Хятад улс 2001 онд ДХБ-д элссэн, Солонгосын хойгийн цөмийн хямралыг зохицуулах талаар гаргаж буй хүчин чармайлт зэрэг болно.

Тийм ч учраас сүүлийн үед өрнөдийн хятад судлаачид “Хятадын шинэ дипломат бодлого” гэсэн нэр томъёог дэвшүүлэн тавьж байна. Тэдний үзэж байгаагаар “Хятадын гадаад бодлогын төлөв байдал нь Хятад орны Мао Зэдун, Дэн Сяопиний үеийн хэлмэгдэн хохирсон, хөгжиж буй үндэстэн бус, харин янз бүрийн ашиг сонирхол, үүрэг хариуцлага бүхий их гүрэн болж буй улс орны түвшинд авч үзэх нөхцөл байдлыг бий болгож байна.”¹.

Хятадын шинэ дипломат бодлого ба хэрэгжилт

Хятадын эрдэмтэн Чэнь Зехуа ХХI зууны Хятадын дипломат бодлогын стратегийн 4 чухал талыг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- их гүрнүүдтэй харилцааг сайжруулан зохицуулах, зонхилох их гүрнүүдийн хооронд гарч болзошгүй эрх ашгийн мөргөлдөөн үүсэхээс зайлсхийх, зөөлрүүлэх,

* Д.Шүрхүү. ШУА-ийн ОУСХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D)

¹ China's New Diplomacy. By Evan S. Medeiros and M. Taylor Fravel. FOREIGN AFFAIRS. Volume 82 No.6 pp-23

- хөрш орнуудтай тогтоосон харилцааг сайжруулан зохицуулах, тэдгээр орнуудын эрх ашгийн зөрчилдөөнийг зөөлрүүлэх,

- “хятадын аюул” гэдгийг няцаан, хүйтэн дайны дараа үүссэн хятадыг хаах, хязгаарлахын тулд олон улс эвсэх байдал гарах болон “шинэ хүйтэн дайн” үүсэхээс сэргийлэх,

- энх тайван орчныг сахин хамгаалж, гадаадын тэргүүний техник-технологийг аль болох ихээр татан оруулж улс орны нийт хүч чадлыг өсгөн нэмэгдүүлэх эдгээр болно.

XX зууны төгсгөл рүү Хятад улс бүс нутгийн их гүрнээс дэлхий хэмжээний эдийн засгийн их гүрэн болон хувирч цаашдаа дэлхийн бодлогод нөлөө бүхий тоглогч-супер их гүрэн болох төлөв харагдаж байна. Энэ нь Хятад улс сансарт иргэнээ бие даан нисгэсэн 3 дахь их гүрэн, дэлхийн хамгийн том хөрөнгө оруулалтыг татагч орон, 2008 оны Олимпийн наадмыг зохион байгуулагч орон гэх мэт олон зүйлээр нотлогдож байна. Өргөжин тэлж буй эдийн засгийн эрх ашгаа хамгаалахын тулд их гүрний хэмжээнд бодлого явуулж, их гүрний эрх дарх, үүрэг хариуцлагаа адил тэнцүү хүлээж, их гүрнүүдтэй нягт харилцах зайлшгүй шаардлага гарч ирсэн. Энэ үүднээс Хятад улс ОХУ-тай стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлж, Европын орнуудтай харилцаагаа идэвхжүүлэн, АНУ-тай байнгын хэвийн харилцаа тогтоохыг эрмэлзэж байна.

“Хятадын шинэ дипломат бодлого”-ын бас нэг чухал чиг шугам бол эдийн засгийн түргэн хөгжилд таатай орчин бүрдүүлэхийн тулд тайван тогтвортой гадаад орчин бүрдүүлэх, ялангуяа хөрш зэргэлдээ орнуудтай урт хугацааны найрсаг харилцаа тогтоох явдлыг чухалчилсан юм. Энэ үүднээс Хятад улс 1990-ээд онуудад Казахстан, Киргизстан, Лаос, ОХУ, Тажикистан, Вьетнам зэрэг хөрш орнуудтай удтал оршиж байсан хилийн асуудлаа зохицуулж, Энэтхэг, Зүүн Өмнөд Ази, Япон зэрэг нутаг

дэвсгэр, усан хилийн маргаантай орнуудтай харилцаагаа ихэд сайжруулж байна.

Хятадын шинэ дипломат бодлогын бас нэг онцлог бол гадаад бодлого, аюулгүй байдлын талаарх бодлого боловсруулах, шийдвэр гаргах механизмд гарч буй өөрчлөлт юм. Энэ өөрчлөлт шийдвэр гаргах механизм илүү институтчлагдах, хувь хүний, эрх баригч бүлгээс хамаарах түвшин буурах тал руу хандаж байна. Өөрөөр хэлбэл бодлого боловсруулах үйл явцад мэргэжсэн дипломатуудаас гадна дотоодын судалгааны байгууллага, тинктанк-төвүүд, нэртэй эрдэмтэн, экспертүүдийг татан оруулах явдал түгээмэл болж байна. Үүнтэй холбогдуулан хэлэхэд Хятадад 2000 оны эцсээр гадаад бодлого, аюулгүй байдлын томоохон асуудлаар дээд түвшинд зөвлөлдөх, шийдвэр гаргах, агентлаг хоорондын үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэг бүхий Үндэсний Аюулгүй Байдлын Удирдах групп байгуулагдсан, Хятадын Гадаад явдлын яаманд Бодлого төлөвлөлтийн газрыг дахин байгуулсан билээ. Мөн түүнчлэн өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд шинэ дипломат бодлогыг гардан хэрэгжүүлэх, өрнөдийн их сургуулиудыг төгссөн, гадаад хэл онолын хувьд сайтар бэлтгэгдсэн дунд, залуу үеийн мэргэжлийн дипломатуудын бүхэл бүтэн үе гарч ирэв.

**Монгол, Хятадын харилцааны
шинэ шат: харилцан ашигтай,
сайн хөршийн түншлэл**

Өмнөд хөрш БНХАУ-ын гадаад бодлогын шинэчлэл нь 1990 оноос ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжин орсон Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтгал, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлоготой ихээхэн нийцэн зохицож байна. БНХАУ-аас хөрш зэргэлдээ орнуудтайгаа сайн хөршийн найрсаг харилцааг бататган хөгжүүлэх явдлыг ихэд чухалчлан гадаад бодлогынхоо чухал бүрэлдэхүүн хэсэг болгосон бол Монгол улс БНХАУ-тай

найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа бүх талаар хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл хэмээн зарласан билээ.

2003 он Монгол-Хятадын харилцааны хувьд онцлог жил байлаа. БНХАУ-ын дарга Ху Жиньтао Монгол улсад төрийн айлчлал хийсэн нь хоёр орны харилцааны хамгийн чухал үйл явдал болов. Ийнхүү БНХАУ-ын дарга Ху Жиньтао төрийн тэргүүний хувиар гадаад орнуудад хийсэн анхны айлчлалынхаа хүрээнд манай оронд айлчилсан явдал нь Хятадын тал, Хятадын шинэ удирдлага Монгол-Хятадын харилцааг чухалчлан үзэж байгаагийн тод илэрхийлэл болсон бөгөөд зөвхөн манай хоёр талын харилцаанд төдийгүй манай улсын нэр хүндийг гадаад ертөнцөд өргөж өгснөөрөө чухал ач холбогдолтой болов. Айлчлалын дүнгээр хоёр тал хамтарсан мэдэгдэл гаргаж, Монгол, Хятадын сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцааг тогтоон хөгжүүлэхээ санал нэгтэй мэдэгдсэн нь хоёр орны харилцааны өнөөгийн хүрсэн түвшинг шат ахиулсан хэрэг боллоо. Худалдаа-эдийн засгийн салбарт хөгжлийн томоохон төсөлд түлхүү анхаарах, худалдаа, хөрөнгө оруулалтын өнөөгийн түвшинг тогтвортой байлгах зорилт тавьж, Хятадын зүгээс Монгол улсад үзүүлэх хөнгөлөлттэй зээл,

буцалтгүй тусламжийн хэмжээг бууруулахгүй байх, тэдгээрийг оновчтой ашиглах, Улаанбаатар, Бээжингийн хооронд суудлын нэмэгдэл галт тэрэг аялуулах зэрэгт голлон анхаарав. Хятадын талаас 50 сая юаний буцалтгүй тусламж үзүүлж, 300 сая ам. долларын хөнгөлөлттэй зээл олгохоо мэдэгдсэн нь хамтын ажиллагааны төслүүдийг хэрэгжүүлэхэд таатай нөхцлийг бүрдүүлэв. Монгол-Хятадын хооронд “Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай” хэлэлцээр байгуулсан бөгөөд Хятадын засгийн газар Монгол улсыг “БНХАУ-ын иргэд өөрийн зардлаар жуулчлах улсуудын жагсаалтад” оруулж байгааг мэдэгдсэн нь аялал жуулчлалын хамтын ажиллагаа хөгжих бодит алхам болов.

БНХАУ манай гадаад худалдааны хамгийн том түнш, гадаадын хөрөнгө оруулалтыг тэргүүлсэн хэвээр байна.

2003 онд Монгол-Хятадын худалдааны нийт эргэлт 448 сая ам.долларт хүрч, манай улсын гадаад худалдааны нийт эргэлтийн (1387,5 сая ам.доллар) 1/3, экспортын бараг тэн хагас, импортын 1/5-г Хятад улс дангаар эзлэх болсноос харахад Монгол орны гадаад худалдааны хамгийн том түнш бол өмнөд хөрш БНХАУ бөгөөд цаашид ч энэ байр суурь улам бэхжин хөгжих төлөвтэй байна.

Монгол-Хятадын худалдааны эргэлт (1990-2003)

Нэгж: сая ам.долл

	1990	1995	1998	1999	2000	2001	2002	2003
Нийт эргэлт	33.6	122.3	143.4	285.8	400.1	374.5	388.2	448.3
МУ-ын нийт эргэлтэд эзлэх %	2%	13.8 %	19%	29.5%	35%	32.3%	32.0%	32.3%
үүнээс: экспорт	11.3	77.8	88.4	208.2	274.3	238.3	220.5	276.7
МУ-ын нийт экспортод эзлэх %	1.7%	14.3 %	29.3 %	45.8%	51.2%	45.7%	42.1%	46.1%
импорт	22.3	44.5	55.0	77.6	125.8	136.2	167.7	171.6
МУ-ын нийт импортод эзлэх %		10.1 %	11.6 %	15.1%	20.5%	21.3%	24.3%	21.8%

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхтгэлүүд

1990 оноос Монголд гадаадаас оруулж буй хөрөнгө оруулалтын талаар Хятад улс тэргүүлэх байр суурь эзэлж байна. Монгол улсын Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагаас гаргасан албан ёсны мэдээ баримтаас харахад 1990-2002 онуудад Монгол улсад нийт 73 орноос 1 тэрбум гаруй ам долларын хөрөнгө оруулснаас 379 сая нь буюу 1/3-ээс их хэсгийг Хятадын бизнесменүүд оруулсан байна. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын тооны хувьд ч өмнөд хөрш маань давамгайлж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулалттай 3042 гаруй компаний 1000 гаруй нь Хятадын хөрөнгө оруулалттай ажээ.

Эдийн засгийн аюулгүй байдал буюу бие даасан байдал нь гадаад орнууд, тэр тусмаа хөршүүдтэйгээ хэр зэрэг харилцан хамаарал бүхий харилцааг хөгжүүлж, хэр зэрэг оюуны өндөр багтаамж, өртөг шингээсэн, өндөр бүтээмжтэй интеграцид орж чадсанаар хэмжигдэх болсон өнөөгийн цаг үед бид Хятадын аль болох эдийн засгийн олон салбарын болон орон нутгийн эрэлт хэрэгцээг хангахуйц олон төрөл бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг дэлхийн зэх зээлийн үнээр санал болгож нийлүүлж чадвал манай улсын эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшил төдийчинээгээр бэхжих болно. Сүүлийн жилүүдэд газрын тос, нүүрс, цайр, алт, зэсийн баяжмал гэх мэт уул уурхайн салбарын шинэ бүтээгдэхүүн, транзит тээвэр, худалдаа, үйлчилгээг Хятадад нийлүүлэх хүчин чадал нэмэгдсэн буюу нэмэгдэх сайхан бололцоо гарч ирж байна. Шинэ нөхцөл бололцоо нь Монгол улсын өргөн уудам нутаг дэвсгэр, түүний хэвлий дор нуугдан буй эрдэс баялаг, Хятадын зах зээлд ойр орших гэх мэт давуу талуудтай нь шууд холбоотой юм. Чухамхүү эндээс Хятадын том зах зээлд байр сууриа эзлэх, харилцан ашигтай, харилцан хамааралтай оршин тогтнохын үндсэн нөхцөл болох Монгол улсын өрсөлдөх чадварыг өсгөн нэмэгдүүлэх асуудал урган гарч ирнэ.

Ойрын 10-20 жилд Монгол улсын хувьд Хятад болон Зүүн Ази, цаашилбал дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц боломжтой гол чиглэлүүд бол уул уурхайн бүтээгдэхүүнийг гүн боловсруулан экспортлох, оюуны өндөр багтаамжтай өртөг шингээсэн бараа бүтээгдэхүүн, дээд зэрэглэлийн үйлчилгээг, (outsourcing гэх мэт) бий болгох гол нөхцөл болох өндөр боловсролтой иргэдтэй болох буюу монгол хүний оюуны өндөр чадавхийг бий болгох явдал юм.

Монгол улсын уул уурхайн салбарын цаашдын хөгжлийн хувь заяанд өмнөд хөрш Хятад улсын эдийн засгийн хөгжил, зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн байдал маш их, магадгүй шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх төлөвтэй байна. Монгол, Хятад хоёр улсын эдийн засгийн харилцааны тэргүүлэх чиглэл болж буй уул уурхайн салбар дахь хамтын ажиллагаа нь маш өргөн хүрээнд, олон чиглэлээр хөгжих бололцоотой юм.

Ойрын жилүүдэд энэ чиглэлд томоохон өөрчлөлт гарах нөхцөл бүрэлдэж байна. Энэ нь юуны өмнө ирэх 3-4 жилд манай улсын уул уурхайн салбарын экспорт хоёр дахин нэмэгдэх төлөвтэй холбоотой юм. Монгол-Хятадын хамтарсан хамгийн том төсөл болох Цайрын баяжуулах үйлдвэр Монгол улсын Сүхбаатар аймагт ирэх онд ашиглалтанд орно. Монгол улсын өмнөд хилийн ойролцоо Хятадын зах зээлд түшиглэн шинээр босч буй дэлхийд томд орох зэх алтны Оюутолгойн орд газрыг 2007 оноос ил уурхайн, 2008 оноос далд уурхайн хэлбэрээр ашиглаж эхлэх бөгөөд өнгөрсөн оноос Хятад руу 400000 тн нүүрс экспортолсон Өмнөговийн Нарийн сухайтын нүүрсний уурхай хүчин чадлаа цаашдаа хоёр сая тоннд хүргэх юм. Хятадад бүтээгдэхүүнээ нийлүүлдэг Эрдэнэт комбинат катодын зэсний үйлдвэрээ энэ онд ашиглалтанд оруулж бүтээгдэхүүний хэмжээ, нэр төрлөө нэмэгдүүлэх болно.

Монгол-Хятадын худалаа, эдийн засгийн харилцаанд хамгийн ирээдүйтэй чиглэл бол

газрын тосны хайгуул, олборлолт, нефть бүтээгдэхүүний худалдаа, тээвэрлэлт юм. Дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ өсөн нэмэгдэхийн хирээр жилээс жилд газрын тосны эрэлт хэрэгцээ, импорт нь өссөр буй Хятадын зах зээлд зориулан Монголд газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлолт хийж буй гадаадын компаниудын үйл ажиллагаа ч улам идэвхижих хандлагатай байна. Монгол улсын зүүн зах Тамсагийн сав газарт газрын тосны 200 сая тн нөөц илэрсэн бөгөөд Хятад руу гаргах газрын тосны хэмжээ жилээс жилд өсч байна (2002 онд 190 мянган баррель).

Монгол улс стратегийн чухал бүтээгдэхүүн болох нефть бүтээгдэхүүний хувьд хойд хөршөөсөө бүрэн хараат байдаг тул сүүлийн жилүүдэд Хятадаас нийлүүлэх арга замыг эрэлхийлж байна. Энэ дашрамд Европын Холбооны тусламжаар БНХАУ-тай хиллэх Замын-Үүд боомт дээр саяхан байгуулсан нефть бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих байгууламж чухал ач холбогдолтой болохыг дурьдах нь зүйтэй юм.

Зам тээвэр, дэд бүтэц бол Монгол-Хятадын харилцааны тэргүүлэх чиглэлд зүй ёсоор орж байна. Монгол улсын гадаадад нээлттэй байх, эдийн засгийн бодлогоо тууштай хэрэгжүүлэх, гадаад худалдаагаа өргөжүүлэн хөгжүүлэх, уул уурхайн салбарт гадаадын томоохон хөрөнгө оруулалтыг татахад зам тээврийн сүлжээ, дэд бүтцийн сул хөгжил ихээхэн саад бэрхшээл учруулж байна. Монгол улс хойд хөрштэйгээ засмал замаар аль эрт холбогдсон боловч өнөөг хүртэл Хятадтай засмал замаар холбогдоогүй байсан юм. Харин сүүлийн жилүүдэд гадаадын зээл тусламжаар ойрын 2-3 жилд энэ сул тал арилах боломжтой боллоо. Улаанбаатараас Хятад улсын хил хүртэлх 700 орчим км замыг хэсэгчлэн барих ажил ид явагдаж байна.

УБТЗ жилээс жилд эрс өсч буй Монгол-Хятад, Орос-Хятад болон тив хоорондын ачаа тээврийн урсгалын ачааллыг улам бүр дийлэхээ болих төлөвтэй байна. Өнгөрсөн жил Ангарск-Дациний хооронд барихаар төлөвлөж байсан нефть хоолойн асуудал тодорхой шалтгааны улмаас хойшлогдсон тул ОХУ-аас Хятадад нийлүүлэх газрын тос ойрын жилүүдэд төмөр замаар, түүний дотор Монголоор дайран өнгөрөхөөр болж байна. 2004 оны эхний улирлын байдлаар Замын-Үүд-Эрээн боомтоор дамжин өнгөрсөн ОХУ-аас Хятадад экспортолсон нефтийн хэмжээ 600,000 т хүрч, гаалийн татвар 200 сая юаньд хүрсэн тухай Синхуа агентлаг мэдээлсэн байна. 2003 онд Хятад улс ОХУ-аас Эрээн боомтоор дамжуулан 1,7 сая тонн нефть импортолсон бол 2004 онд 2,5 сая тн нефть импортлох төлөвлөгөөтэй байна. ОХУ-ын талын мэдээлснээр Орос-Хятадын нефтийн компаниуд 2004 онд нийтдээ 6.4 сая, 2005 онд 8.5 сая тн нефть, цаашдаа жил бүр 15 сая тн нефть нийлүүлэх гэрээ байгуулаад байгаа ажээ.

Иймд Монголын нутгаар дайран өнгөрөх транзит ачааны хэмжээ эрс нэмэгдэх бөгөөд тэр хэмжээгээр Монголын эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр болно.

Сүүлийн жилүүдэд Монгол-Хятадын улс төр, бизнесийн хүрээний анхаарал сонирхлыг ихэд татаж буй өөр нэг чухал асуудал бол Замын-Үүд боомтыг түшиглэн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах ажил юм. Хятад улс чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүс байгуулах талаар арвин туршлагатай орон төдийгүй Замын-Үүдийн чөлөөт бүсийн хөгжүүлэх гол зах зээл, мөн томоохон хөрөнгө оруулагч байж болох бүрэн үндэслэлтэй юм.

Монгол улсын УИХ-аас Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай, Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай, Замын-Үүдийн чөлөөт эдийн засгийн бүсийн тухай хуулиудыг 2002-2003 онд батлан гаргасан. Монгол Улсын Засгийн

газраас дээрх хууль тогтоомжуудыг үндэслэн үйлдвэрлэл, худалдаа болон аялал жуулчлал-үйлчилгээний (казиног оролцуулан) гэсэн үндсэн 3 хэлбэрээс бүрдэх “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс (цаашид “ЭЗЧБ” гэж товчлох)-ийг иж бүрнээр нь байгуулж хөгжүүлэх, вйл ажиллагааг нь менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх стратегийн хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор олон улсын нээлттэй тендерийг зарлаад байна.

Монгол-Хятад хоёр орон глобалчлал, шинжлэх ухаан техникийн хөгжлийн сөрөг тал болон гарч буй цөлжилт, шороон шуурга, САРС, малын гоц халдварт өвчин, хар тамхи, ДОХ, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэг дэлхий нийтийг хамарсан глобал асуудлуудтай ч тулгарах болсон бөгөөд гагцхүү хоёр ба олон талын хүч чармайлт, нягт хамтын ажиллагаагаар энэхүү сорилтыг сөрөн зогсож чадна.

Олон улсын террористуудын өдөөсөн 9.11-ний балмад халдлага олон улсын

харилцаанд нэлээд өөрчлөлт, шинэ сорилтуудыг авчирсан билээ. Монгол улсын хувьд терроризмын аливаа илрэлийг эсэргүүцсэн тууштай бодлого явуулж, АНУ тэргүүтэй эвслийн бүрэлдэхүүнд Афганистан, Иракийн сэргээн босголтод манай улсын энхийг сахиулах багийг ажиллуулж байна. Мөн түүнчлэн Монгол улс хөрш ОХУ, Хятад улсын санаачилгаар Төв Азийн аюулгүй байдал, итгэлцэл, хамтын ажиллагааг хөгжүүлж, олон улсын терроризмыг эсэргүүцэх чиглэлээр байгуулагдсан Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын цаашдын хөгжлийн төлөв байдлыг анхааралтай ажиглаж байна.

Монгол-Хятадын харилцааны хөгжлийн одоогийн өндөрлөгөөс харахад хоёр ард түмний харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх сайхан ирээдүй, хөгжлийн их нөөц бололцоо байна. Бидний нийтлэг зорилго бол харилцан хүндэтгэх, харилцан итгэлцэх, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан хамтын хөгжил цэцэглэлд хүрэх явдал билээ.

